

САНАЛ

Та сурах бичгийн зохиогчийн эхийн талаар дараах асуултад бодитой, бүрэн хариулж бидний ажилд дэмжлэг болно уу. Таны ирүүлсэн санал сурах бичгийн эхийг сайжруулахад чухал ач холбогдолтой байх болно.

Нэг. Ерөнхий мэдээлэл:

Овог, нэр	Сургууль	Мэргэжил	Ажилласан жил	Мэргэжлийн зэрэг	Хүйс

Сурах бичгийн нэр:

Анги:

Хоёр. Агуулга:

Д/д	Шалгуур	Сэдвийн нэр	Тийм	Үгүй	Сайжруулах санал, зөвлөмж
1	Сэдэв бүрд сургалтын цөм хөтөлбөрийн агуулгыг бүрэн тусгасан эсэх				
2	Бичвэр болон бичвэр бус мэдээлэл (бүдүүвч, зураг г.м) нь сэдвийн агуулгатай уялдсан эсэх				
3	Сэдэв бүрийн агуулга нь өмнөх ангийн агуулгатай залгамж холбоо, логик дэс дараалалтай эсэх				
4					

Гурав. Арга зүй, даалгавар:

Д/д	Шалгуур	Сэдэв, даалгаврын дугаар	Тийм	Үгүй	Сайжруулах санал, зөвлөмж
1	Бүлэг, сэдвийг судлах зааварчилгаа нь ойлгомжтой эсэх				
2	Дасгал, даалгавар нь агуулгатай нийцэж буй эсэх				
3	Ойлгомжгүй, хариу гарахгүй даалгавар, тохиолдол, дадлага ажил, сорил буй эсэх				
4	Өөрийгөө үнэлэх үнэлгээний даалгаврыг тусгасан эсэх				
5					

Дөрөв. Хэл найруулга, зураг дизайн:

Д/д	Шалгуур	Сэдэв, даалгаврын дугаар	Сайжруулах санал, зөвлөмж
1	Найруулгатай холбоотой		
2	Зөв бичгийн дүрэмтэй холбоотой		
3	Мэргэжлийн үг, хэллэгтэй холбоотой		
4			

Амжилт хүсье.


ДҮРСЛЭХ ГЕОМЕТР

1.1 .1 Хавтгайн проекц (онцгой байршилтай)

Өмнөх ангид цэгийн проекц, шулууны проекцын тухай мэдлэгтэй болсон билээ. Геометр дүрсийн (цэг, шулуун, хавтгай) проекцын мэдлэг нь техникийн зургийн дүрслэлийг уншиж ойлгох, зурах, хэрэглэхэд чухал ач холбогдолтой байдаг.


Дүрслэх геометрт хавтгайг дараах байдлаар өгөх ба дүрсэлнэ. (1.1 дүгээр зураг) Үүнд:

- а. Нэг шулуун дээр биш гурван цэгээр
- б. Шулуун, түүний гадна орших цэгээр
- в. Огтлолцсон хоёр шулуунаар
- г. Параллел хоёр шулуунаар
- д. Хавтгай олон өнцөгтөөр (гурвалжин, дөрвөлжин гэх мэт)
- е. Мөрөөр



1.1 дүгээр зураг

Хавтгайн мөр. Хавтгай проекцын хавтгайтай огтлолцоход үүсэх шулууныг хавтгайн мөр гэж нэрлэдэг. (1.2 дугаар зураг)




1.2 дугаар зураг


Хавтгайн байршил.

харьцуулахад хавтгай ерөнхий ба онцгой байршилтай байдаг.


Проекцын хавтгайтай



Бид зөвхөн онцгой байршилтай (түвшний ба проекцлогч) хавтгайн талаар судлах болно. Проекцын аль нэг хавтгайтай параллел байрласан хавтгайг түвшний хавтгай гэж нэрлэдэг.




Хавтгай, проекцын нүүрний хавтгайтай параллел бол нүүрний түвшний хавтгай гэж нэрлэдэг. (1.3 дугаар зураг)



1.3 дугаар зураг

Хавтгай, хэвтээ хавтгайтай параллел бол хэвтээ түвшний хавтгай гэж нэрлэнэ. (1.4 дүгээр зураг)


Хэвтээ түвшний хавтгайн нүүрний проекц болон хажуугийн проекцыг гүйцээн байгуулаарай.



1.4 дүгээр зураг

Хавтгай, хажуугийн хавтгайтай параллел бол хажуугийн түвшний хавтгай гэж нэрлэнэ. (1.5 дугаар зураг)

Хажуугийн түвшний хавтгайн нүүрний проекц болон хэвтээ проекцыг гүйцээн байгуулаарай.



1.5 дугаар зураг


Проекцын аль нэг хавтгайд хавтгайг проекцлогч байршилтай хавтгай гэнэ.

перпендикуляр байршилтай

Проекцлогч хавтгай


- Хэвтээд проекцлогч ($\alpha \perp \pi_1$)
- Нүүрт проекцлогч ($\alpha \perp \pi_2$)
- Хажууд проекцлогч ($\alpha \perp \pi_3$)

Хавтгай, проекцын хэвтээ хавтгайд перпендикуляр байршилтай бол хэвтээд проекцлогч хавтгай гэнэ. (1.6 дугаар зураг)




1.6 дугаар зураг

Хавтгай, проекцын нүүрний хавтгайд перпендикуляр байршилтай бол нүүрт проекцлогч хавтгай гэнэ. (1.7 дугаар зураг)




1.7 дугаар зураг

Хавтгай, проекцын хажуугийн хавтгайд перпендикуляр байршилтай бол хажууд проекцлогч хавтгай гэнэ. (1.8 дугаар зураг)




1.8 дугаар зураг


Огтлолцсон хоёр шулуунаар өгөгдсөн хэвтээд проекцлогч байршилтай хавтгайн проекцыг байгуулсан жишээг 1.9 дүгээр зургаас үзнэ үү.



Параллел шулуунаар өгөгдсөн нүүрт проекцлогч хавтгай (1.10 дугаар зураг), гурвалжнаар өгөгдсөн хажууд проекцлогч хавтгайн (1.11 дүгээр зураг) проекцыг гүйцээж байгуулаарай.



1.10 дугаар зураг



1.11 дүгээр зураг